



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/133/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор:      Б.Азбаяр Утас: 99061429      Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	--

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/ .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/ .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/ .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ .....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.9.2 Засгийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт.....	15
3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

*2022.02.25* № *2/38*

БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Г.МӨНХСҮХ ТАНАА

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянлиг сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянлиг сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

005020788

D:\Alban bichig\A4-toot.docx

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text, including the title 'ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР' (Auditor General) and the name 'Б.МӨНХБАТ' (B. Mönkhbat).

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>39,670,398.50</b>	<b>71,007,800.50</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	505,708.00	6,735,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	357,208.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	148,500.00	6,735,000.00
3351	Байгууллагаас авах авлага	148,500.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	6,735,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	39,164,690.50	64,272,800.50
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	2,047,390.00	2,989,390.00
35110	Тусгай зориулалттай материал	2,047,390.00	2,989,390.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	33,157,300.50	57,323,410.50
35410	Бичиг хэргийн материал	3,421,714.00	3,456,424.00
35420	Аж ахуйн материал	17,709,520.00	34,523,520.00
35440	Түлш, шатах тослох материал	60,000.00	604,500.00
35470	Бусад хангамжийн материал	11,966,066.50	18,738,966.50
35600	Мал амьтад	3,960,000.00	3,960,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,385,462,736.11</b>	<b>3,233,923,702.04</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,385,462,736.11	3,233,923,702.04
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,293,932,023.61	3,135,023,271.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,925,216,510.10	3,943,945,710.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,137,377,558.78)	(1,326,016,403.66)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	242,097,800.00	287,097,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(137,635,315.27)	(168,118,697.63)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	299,245,964.90	317,369,578.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	(138,876,093.26)	(174,180,476.71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	130,632,239.09	130,171,639.09
39208	Хуримтлагдсан элэгдэл	(74,311,285.34)	(83,788,608.82)
39209	Зам, гүүрийн байгууламж	13,612,310.00	32,752,760.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(2,898,456.94)	(3,579,072.46)
39214	Бусад үндсэн хөрөнгө	242,494,676.00	265,758,815.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(68,268,766.89)	(86,389,772.43)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	91,530,712.50	98,900,430.91
39301	Програм хангамж	2,704,060.00	2,704,060.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,967,601.67)	(2,267,601.67)
39303	Бусад биет бус хөрөнгө	91,092,950.00	103,482,750.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(298,695.83)	(5,018,777.42)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,425,133,134.61</b>	<b>3,304,931,502.54</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,425,133,134.61</b>	<b>3,304,931,502.54</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,425,133,134.61	3,304,931,502.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	505,387,011.50	505,387,011.50
51101	Өмч: - төрийн	505,387,011.50	505,387,011.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,833,996,250.41	2,721,859,968.34
51210	Өмнөх үеийн үр дүн	2,833,996,250.41	2,842,061,600.41
51220	Тайлант үеийн үр дүн	-	(120,201,632.07)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	85,749,872.70	77,684,522.70

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,425,133,134.61	3,304,931,502.54
---	--	------------------	------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	478,273,368.00	654,842,153.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,102,800.00	221,901,849.00
120	Нийтлэг татварын бус орлого	66,102,800.00	221,901,849.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	66,102,800.00	221,901,849.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,200,000.00	6,498,960.00
120017	Үнэ төлбөргүй орлого /үндсэн хөрөнгө/	61,902,800.00	151,004,889.00
120018	Үнэ төлбөргүй орлого /бараа материал/	0.00	64,398,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	412,170,568.00	432,940,304.63
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,553,168.00	40,369,304.63
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,110,168.00	5,961,605.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,443,000.00	34,407,699.63
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	379,617,400.00	392,571,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	379,617,400.00	392,571,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	742,960,153.71	761,203,797.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	742,960,153.71	761,203,797.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	724,017,295.71	755,595,359.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	237,555,514.00	224,427,535.00
210101	Үндсэн цалин	237,555,514.00	224,427,535.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,115,874.00	29,187,962.81
210201	Тэтгэврийн даатгал	30,115,874.00	20,558,425.81
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	2,244,271.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	1,795,417.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	417,258.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	4,172,591.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,224,750.00	32,627,688.83
210301	Гэрэл, цахилгаан	11,829,750.00	4,600,148.93
210302	Түлш, халаалт	18,001,000.00	28,027,539.90
210303	Цэвэр, бохир ус	394,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	92,651,889.00	123,874,982.10
210401	Бичиг хэрэг	4,442,800.00	5,894,290.00
210402	Тээвэр, шатахуун	37,435,439.00	31,932,092.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,526,000.00	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	11,929,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,146,450.00	74,019,600.00
210408	Бараа материал акталсны зардал	6,981,200.00	0.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	646,700.00	6,579,000.00
210604	Урсгал засвар	646,700.00	6,579,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,178,000.00	2,496,700.00

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	3,178,000.00	2,496,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,101,475.00</b>	<b>13,009,046.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,101,475.00	9,245,046.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	200,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	3,564,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>313,543,093.71</b>	<b>323,392,444.87</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,882,900.00	25,488,910.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	305,660,193.71	297,903,534.87
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,942,858.00</b>	<b>5,608,437.89</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,739,100.00</b>	<b>0.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,239,100.00	0.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>14,203,758.00</b>	<b>5,608,437.89</b>
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	1,995,000.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,208,758.00	5,311,915.26
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(264,686,785.71)</u></b>	<b><u>(106,361,643.87)</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>13,839,988.20</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	13,839,988.20
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>0.00</b>	<b>(13,839,988.20)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(264,686,785.71)</u></b>	<b><u>(120,201,632.07)</u></b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>416,370,568.00</u></b>	<b><u>439,439,264.63</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,200,000.00</b>	<b>6,498,960.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>4,200,000.00</b>	<b>6,498,960.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,200,000.00	6,498,960.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,200,000.00	6,498,960.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>412,170,568.00</b>	<b>432,940,304.63</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>32,553,168.00</b>	<b>40,369,304.63</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,110,168.00	5,961,605.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,443,000.00	34,407,699.63
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>379,617,400.00</b>	<b>392,571,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	379,617,400.00	392,571,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>414,870,568.00</u></b>	<b><u>423,504,664.63</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>414,870,568.00</b>	<b>423,504,664.63</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>395,927,710.00</b>	<b>417,421,126.74</b>

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	237,952,996.00	223,734,497.00
210101	Үндсэн цалин	232,756,406.00	204,857,217.00
210102	Нэмэгдэл	0.00	18,877,280.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,424,306.00	0.00
210104	Урамшуулал	3,772,284.00	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,537,622.00	29,511,292.81
210201	Тэтгэврийн даатгал	20,432,263.00	20,764,762.80
210202	Тэтгэмжийн даатгал	2,319,684.00	2,196,472.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,903,600.00	1,756,796.89
210204	Ажилгүйдлийн даатгал	421,694.00	432,790.44
210205	Эрүүл мэндийн даатгал	4,460,381.00	4,360,470.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,284,750.00	28,460,634.93
210301	Гэрэл, цахилгаан	5,005,350.00	3,629,434.93
210302	Түлш, халаалт	24,885,400.00	24,831,200.00
210303	Цэвэр, бохир ус	394,000.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	31,064,600.00	50,991,100.00
210401	Бичиг хэрэг	4,342,600.00	5,970,000.00
210402	Тээвэр, шатахуун	24,836,000.00	29,868,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,516,000.00	25,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	13,648,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,000.00	1,479,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,000,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	804,000.00	10,642,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	65,000.00
210604	Урсгал засвар	804,000.00	10,577,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,008,000.00	2,496,700.00
210702	Дотоод албан томилолт	3,008,000.00	2,496,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	38,819,603.00	48,099,676.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,819,603.00	44,335,676.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	200,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	3,564,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	23,456,139.00	30,220,226.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,456,139.00	30,220,226.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,942,858.00</b>	<b>6,083,537.89</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,739,100.00	475,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,239,100.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	475,100.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	14,203,758.00	5,608,437.89
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	1,995,000.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,208,758.00	5,311,915.26
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>1,500,000.00</u></b>	<b><u>9,199,600.00</u></b>

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,500,000.00	9,199,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,500,000.00	9,199,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,500,000.00	9,199,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,500,000.00	9,199,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,500,000.00)</u>	<u>(9,199,600.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,387,011.50	85,749,872.70	2,833,996,250.41	00.00	3,425,133,134.61
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	505,387,011.50	85,749,872.70	2,833,996,250.41	00.00	3,425,133,134.61
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,387,011.50	85,749,872.70	2,833,996,250.41	00.00	3,425,133,134.61
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,387,011.50	85,749,872.70	2,833,996,250.41	00.00	3,425,133,134.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	8,065,350.00	00.00	8,065,350.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	505,387,011.50	85,749,872.70	2,842,061,600.41	00.00	3,433,198,484.61
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-8,065,350.00	00.00	00.00	-8,065,350.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-120,201,632.07	00.00	-120,201,632.07
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,387,011.50	77,684,522.70	2,721,859,968.34	00.00	3,304,931,502.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	393,571,000.00	391,459,084.74	2,111,915.26	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	393,571,000.00	391,459,084.74	2,111,915.26	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	393,071,000.00	390,983,984.74	2,087,015.26	99.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,245,000.00	223,734,497.00	510,503.00	99.8
210101	Үндсэн цалин	194,693,500.00	204,857,217.00	(10,163,717.00)	105.2
210102	Нэмэгдэл	29,551,500.00	18,877,280.00	10,674,220.00	63.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,273,100.00	29,511,292.81	761,807.19	97.5
210201	Тэтгэврийн даатгал	21,303,300.00	20,764,762.80	538,537.20	97.5
210202	Тэтгэмжийн даатгал	2,242,400.00	2,196,472.26	45,927.74	98.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,794,000.00	1,756,796.89	37,203.11	97.9
210204	Ажилгүйдлийн даатгал	448,500.00	432,790.44	15,709.56	96.5
210205	Эрүүл мэндийн даатгал	4,484,900.00	4,360,470.42	124,429.58	97.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,474,300.00	28,460,634.93	13,665.07	100.0
210301	Гэрэл, цахилгаан	3,640,400.00	3,629,434.93	10,965.07	99.7
210302	Түлш, халаалт	24,833,900.00	24,831,200.00	2,700.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	51,713,100.00	50,942,140.00	770,960.00	98.5
210401	Бичиг хэрэг	5,984,300.00	5,921,040.00	63,260.00	98.9
210402	Тээвэр, шатахуун	29,868,100.00	29,868,100.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	51,700.00	25,000.00	26,700.00	48.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,329,000.00	13,648,500.00	680,500.00	95.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,480,000.00	1,479,500.00	500.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,854,500.00	19,841,600.00	12,900.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	9,999,600.00	400.00	100.0
210604	Урсгал засвар	9,854,500.00	9,842,000.00	12,500.00	99.9
2107	Томилолт, зочны зардал	2,497,000.00	2,496,700.00	300.00	100.0
210702	Дотоод албан томилолт	2,497,000.00	2,496,700.00	300.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,028,900.00	8,026,894.00	2,006.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,264,900.00	4,262,894.00	2,006.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00		100.0

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00	-	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	27,985,100.00	27,970,226.00	14,874.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,985,100.00	27,970,226.00	14,874.00	99.9
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	500,000.00	475,100.00	24,900.00	95.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	500,000.00	475,100.00	24,900.00	95.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	475,100.00	24,900.00	95.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	393,571,000.00	391,459,084.74	2,111,915.26	99.5
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	392,571,000.00	387,259,084.74	5,311,915.26	98.6
132001	Орон нутгийн төсвөөс	392,571,000.00	387,259,084.74	5,311,915.26	98.6
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,000,000.00	4,200,000.00	(3,200,000.00)	420.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	4,200,000.00	(3,200,000.00)	420.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	24	24	-	100.0
620001	Удирдах ажилтан	3	3	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	5	5	-	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/**

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>32,553,168.00</b>	<b>40,369,304.63</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>32,553,168.00</b>	<b>40,369,304.63</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	32,553,168.00	40,369,304.63
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	32,553,168.00	40,369,304.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,553,168.00	40,369,304.63
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>32,553,168.00</b>	<b>40,369,304.63</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>32,553,168.00</b>	<b>40,369,304.63</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,110,168.00	5,961,605.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,443,000.00	34,407,699.63
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00



### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт төсвийн гүйцэтгэлийн аудит хийлгэх хүсэлтийг 2022 оны 01 дүгээр сарын 13-ний өдөр ирүүлсэн байна.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын үсгийг ЗДТГ-ын дарга Г.Мөнхсүх, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Г.Тунгалаг нар зурсан байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Төрийн үйлчилгээ бодлого шийдвэрийг ард иргэдэд түргэн шуурхай хүргэж тэдний санал бодлыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх зорилго тавьж ажилласан

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, бусад эрх зүй актуудыг удирдлага болгон сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр, Тамгын газрын ойрын болон хэтийн төлөвлөгөөний биелэлтийг хянах, байгууллага, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хуулийн дагуу тасралтгүй шуурхай хүртээмжтэй хүргэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.



Аймгийн Санхүү, хяналт аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 742,960.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,429.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,200.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 5,328.4 мянган төгрөг байгаа тул төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 120,201.6 мянган төгрөгөөр буюу 4.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
A	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,670.4	71,007.8	31,337.4
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	505.7	6,735.0	6,229.3
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	39,164.7	64,272.8	25,108.1
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,385,462.7	3,233,923.7	(151,539.0)

Үндсэн хөрөнгө	4,947,096.5	5,083,283.1	136,186.6
Хуримтлагдсан элэгдэл	(1,561,633.8)	(1,849,359.4)	(287,725.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,425,133.1</b>	<b>3,304,931.5</b>	<b>(120,201.6)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,425,133.1	3,304,931.5	(120,201.6)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,425,133.1</b>	<b>3,304,931.5</b>	<b>(120,201.6)</b>

Өмнөх онд авлагын данс 505.7 мянган төгрөг байсан бол тайлант онд 6,735.0 мянган төгрөг болж 6,229.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь байгууллагын урсгал засвар хаалга хийхээр 6,000.0 мянга, принтерийн үнэ 735.0 мянган төгрөгийг тус тус авлагаар бичсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 64,272.8 мянган төгрөг болж 25,108.1 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 16,814.0 мянга, түлш шатах тослох материал 544.5 мянга, бичиг хэргийн материал 34.7 мянга, тусгай зориулалтын материал 942.0 мянга, бусад хангамжийн материал 6,772.9 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,083,283.1 мянган төгрөг болж 136,186.6 мянган төгрөгөөр өссөн нь сумын ОНХС-гийн хөрөнгөөр 131,470.6 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй бүртгэсэн, Монголын цахилгаан холбооны 12,389.8 мянган төгрөгийн шилэн кабель, малын эмч нарын 7,144.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр 9,199.6 мянган төгрөгийн 4 ширхэг компьютер худалдан авч бүртгэсэнтэй холбоотой байна. Тайлант онд аймгийн ИТХ-ын 116 тоот тогтоолоор 24,017.9 мянган төгрөгийн төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,304,931.5 мянган төгрөг болж 120,201.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг 550,319.1 мянган төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг төсвөөс 546,119.1 мянга, үйл ажиллагааны орлогоос 4,200. мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 156,748.1 мянган төгрөгөөр бууруулж 393,571.0 мянган төгрөгөөр анх батлагдсан байна. Төсөвлөсөн зардлаас цалингийн зардлыг 132,296.8 мянга, ЭМНДШ-ийг 39,783.4 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 18,551.3 мянга, хангамж материалын зардлыг 281.3 мянга, томилолтын зардлыг 8,500.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 393,571.0 мянган төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс 392,571.0 мянга, өөрийн орлогоор 1,000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.



Гүйцэтгэлээр төсвөөс мянган төгрөгийн 392,571.0 санхүүжилт авч өөрийн орлогоор 4,200.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн, 391,459.1 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 2,111.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 391,459.1 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа бөгөөд тайлант онд цалингийн зардал 510.5 мянга, ЭМНДШ-ийн зардал 761.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 13.7 мянга, томилолтын зардал 160.0 мянга, хангамж материалын зардал 771.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллага нь 2021 онд нэмэлт санхүүжилтийн дансаар Статистикийн хэлтсээс тооллогын зардалд 1,225.3 мянга, аймгийн ЗДТГ-аас өвс тээвэрлэлтийн зардалд 3,136.3 мянга, ЗГ-аас усны үнийн хөнгөлөлтөд 4,092.0 мянга, хамтарсан багийн зардалд 300.0 мянга, өвсний орлогоор 29,798.9 мянга, шүлхий өвчний зардалд 1,300.0 мянга, тендерийн материалын орлого 490.0 мянган төгрөг бусад 148.5 мянга нийт 40,517.8 мянган төгрөг төвлөрч 40,221.3 мянган төгрөгийн зарцуулан оны эцэст 296.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор М.Алтантуяа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Төрийн захиргааны албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж улирал тутамд дүгнүүлэн ажилласан. Засаг даргын тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг жилийн эцсийн байдлаар 90.0 хувьтай хэрэгжсэн.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 761,203.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 18,243.6 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд тээвэр шатахуун, бараа үйлчилгээний бусад зардлууд нь өмнөх оноос өссөн бол бусад зардлууд буурсан үзүүлэлттэй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 533,056.4 мянган төгрөгийн үнийн дүнтэй 151 мэдээллийг байршуулахаас 533,056.4 мянган төгрөгийн 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна. Харин 2 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	0
3	Улирал бүр	1	4	4	0	0
4	Сар бүр	3	36	36	0	0
5	Тухай бүр	8	96	96	0	0
6	Нийт	27	151	149	0	2

### 3.9.2 Засгийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- Тайлант онд 393,571.0 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж гүйцэтгэлээр 391,459.1 мянган төгрөгийг зарцуулж, 2,111.9 мянган төгрөг буюу 0.5 хувийг хэмнэсэн байна.

- Албан томилолтын зардлыг 2,497.0 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 2,796.7 мянган төгрөг зарцуулж 0.3 мянган төгрөг хэмнэжээ.

- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 28,474.3 мянган төгрөгөөр төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 28,460.6 мянган төгрөг зарцуулж, анх баталсан дүнгээс 13.7 мянган төгрөг буюу 0.1 хувь хэмнэсэн нь ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20 хувь бууруулж хэмнэх дээрх тогтоолын 1.8 дах заалтыг хэрэгжүүлээгүй байна.

### 3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд ЕБС-ийн хүнс, болон үдийн цайны зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 63,232.7 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 16,059.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг сумын ЗДТГ-ын даргын 2021.05.21-ний өдрийн 40 тоот албан бичгээр хариуг ирүүлсэн боловч зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12,416.2 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэн тул зөрчил давтан гаргахгүй байх, таслан зогсоох зөвлөмж хүргүүлэв.

### 4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1.1. Илрүүлэлт:

Урсгал засвар хийлгэхээр “Далай Ээж Баянхонгор” ХХК-д хаалга болон засварын 6,000.0 мянган төгрөгийг 2021.12.03-нд, мөн принтер авах зорилгоор иргэн Сэлнэнд 735.0 мянган төгрөгийг 2021.12.27-нд шилжүүлэн авлага үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасан “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### 1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулж өр, авлага үүсгэхгүй, Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн, 2021 онд үүссэн авлагыг барагдуулж гүйцэтгэлийн тайланг ирүүлэх.

#### 2.1. Илрүүлэлт:

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 28,474.3 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 28,460.6 мянган төгрөг зарцуулж Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8<sup>1</sup> дахь заалтаар 20 хувь буюу 5,694.9 мянган төгрөг хэмнэхээс 13.7 мянган төгрөг буюу 0.1 хувь хэмнэсэн нь тогтоолыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

#### 2.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол, журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянлиг сумын ЗДТГ	2	12,416.2	0	0	0	0	0	0	2	12,416.2

оОо



<sup>1</sup> байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах